



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/501

Хэрлэн сум

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх намрын дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/251 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээний бүх үхэр, тугал, гахайг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 20 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6.5, 6.6, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгэх, уг ажлын явц, чанарт хөндлөнгийн хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газрын Хяналтын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5.Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 05-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажилд хяналт тавьж,
хариуцан ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарь

Д/д	Сумын нэр	Засаг дарга	Хяналт тавьж ажиллах Онцгой комиссын гишүүдийн овог нэр	Албан тушаал
1	Галшар	Д.Нямбаатар Утас:99567878	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
2	Баянхутаг	Б.Амгаланбат Утас: 98636699	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
3	Баянмөнх	Б.Золжаргал Утас: 99278000	О.Баяр-лхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Ж.Энхтөр Утас: 98091117	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
5	Дэлгэрхаан	Э.Төгөлдөр Утас: 98632196	Ж.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Л.Цэнгэл Утас: 92113175	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	С.Золжаргал Утас: 97186060	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
8	Өмнөдэлгэр	Б.Эрдэнэбаатар Утас: 88092147	Б.Дарханбаатар	Хууль зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Г.Гансүх Утас: 86067052	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Э.Мөнх-Очир Утас: 97031765	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
11	Баян-Адарга	О.Лхагвадорж Утас: 98819081	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Д.Мөнх-Од Утас: 93014267	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	А.Мөнхбайгаль Утас: 99665599	Ч.Гантогтох	Онцгой байдлын газрын хошууч
14	Батноров	Б.Жавхланбаяр Утас: 91114371	Л.Өлзийбат	Улаан загалмайн хорооны дарга
15	Баян-Овоо	Д.Баянмөнх Утас: 93191029	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
16	Мөрөн	Ц.Батцоож Утас: 98022002	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	М.Шүрэнцэцэг Утас:92113141	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга
18	Бор-Өндөр	Г.Адъяабилэгт Утас: 88887811	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга